

Мал эмнэлэг, үржлийн газрын даргын
2018 оны дугаар сарын ...-ны өдрийн дугаар
тушаалын.... дүгээр хавсралт.

МАЛ ЭМНЭЛГИЙН ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Мал эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ (цаашид “ёс зүйн хэм хэмжээ” гэх) нь Монгол Улсын Үндсэн хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон энэхүү ёс зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

1.2.Малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Малын эмч, туслах ажилтны ёс зүйн журмыг батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага тооцож ажиллана.

1.3.Ёс зүйн хэм хэмжээ нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-д заасан төв, орон нутгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, хувийн хэвшилд ажиллаж байгаа мэргэжилтнүүд, малын их, бага эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан нарт хамаарна.

1.4.Шаардлагатай тохиолдолд энэхүү ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн ажил, үйчилгээ, мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн нэмэлт хэм хэмжээг тухайн байгууллагын мэргэжлийн зөвлөл боловсруулж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж, мөрдүүлнэ.

1.5.Мал эмнэлгийн салбарын мэргэжилтэн, малын их, бага эмч, техникийн ажилтан нар нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах, хариуцлага хүлээх, шударга ёс, хөнгөн шуурхай, хүртээмжтэй үйлчлэх зарчмыг баримтална.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

Мал эмнэлгийн салбарын мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд хэрэглэгдсэн зарим нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

2.1.Малын эмч, мэргэжилтний ёс зүй:- гэж малын эмч, мэргэжилтэн, техникийн ажилтны үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн уламжлал, соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг;

2.2.Малын эмч, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ:- гэж малын эмч, мэргэжилтэн, техникийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон дэг жаягийг;

2.3.Малын эмч, мэргэжилтний ёс зүйн горим:- гэж малын эмч, мэргэжилтэн, техникийн ажилтны мал бүхий иргэд, бусад үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмыг;

2.4.Мал эмнэлгийн мэргэжилтэн:- гэж мал эмнэлгийн боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн тасагт мэргэжлээрээ ажиллаж байгаа малын их, бага эмч нарыг;

2.5.Малын эмч:- гэж мал эмнэлгийн боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн, Мал эмнэлгийн удирдах дээд болон аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдах ажилтан, мэргэжилтэн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий бүх шатны мал эмнэлгийн лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, багш, хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид ажиллаж байгаа малын их, бага эмч нарыг;

2.6.Мал:- гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.1 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.6.Тэжээвэр амьтан:- гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.7.Зэрлэг амьтан:- гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.3 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.8.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах гэж:- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.5 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.9.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх:- гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.6 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.10.Мал, амьтны өвчинтэй тэмцэх гэж:- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.7 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.11.Мал эмнэлгийн үйлчилгээ:- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.8 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.12.Мал эмнэлгийн салбарын байгууллага:- гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.13.Техникийн ажилтан:- гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30.21 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.14.Малчин:- гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн¹ 3.1.9-д заасан иргэнийг;

2.15.Бэлэг:- гэж “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3.1.9 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.16.Хандив:- гэж “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3.1.8 дах заалтаар тодорхойлсон ойлголтыг;

2.17.Давуу байдал:- гэж “Авлигын эсрэг” хуулийн 3.1.4 дэх заалтаар тодорхойлсон ойлголтыг;

¹Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 40 дугаарт нийтлэгдсэн.

2.18. Үйлчлүүлэгч:- гэж мал эмнэлгийн тусламж, үйлчилгээг авахтай холбоотой харилцаанд оролцогч байгууллага, иргэнийг;

2.19. Үйлчлүүлэгчийн нууц:- гэж мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад малын эмч, мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн яриа, бусдаас олж авсан мэдээлэл болон “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн 4.2.2 дах заалтад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг;

2.20. Үл ялгаварлан гадуурхах:- гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна төрх байдал, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, хүн амын тодорхой бүлэгт харъяалагдах байдлаар алагчлахгүй байхыг;

Гурав. Мал эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ.

3.1. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, тэхникийн ажилтан нь шинжлэх ухааны мэдлэгт суурилсан мал эмнэлгийн үйлчилгээг хөнгөн, шуурхай, чанартай төгс үзүүлэхэд өөрийн мэдлэг, чадвар, дадлага туршлагыг бүрэн зориулж, боловсон, энэрэнгүй, шударга ёсны зарчмыг баримтална;

3.2. Мал эмнэлгийн үйлчилгээг үл ялгаварлан малчин, мал бүхий бүх иргэдэд тэгш, хүргээмжтэй үзүүлнэ;

3.3. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь үйл ажиллагаандаа салбарынхаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, байгууллагын дотоод журам, удирдамж, заавруудыг чанд мөрдөж ажиллана;

3.4. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын их, бага эмч, тэхникийн ажилтан нь мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж, шаардлагатай бол хүссэн сургалтад хамрагдах, бусдаас зөвлөгөө авах, мэдлэг, ур чадвараа харилцан солилцох, дээшлүүлэх, шинжлэх ухааны ололт, нээлтийг ажилдаа бүтээлчээр нэвтрүүлэх, өөрийн мэдлэг, чадвар, дадлагаа бусдад зааж сургах, ямарч хамт олонтой найрсаг, хамтран ажиллах ёс зүйг баримтлана;

3.5. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч нь аливаа дүгнэлт, шийдвэрийг бодит байдалд нийцүүлэн, мэргэжлийн чиг баримжаатай үнэн зөв, бодитой гаргаж мэдээлэх, шаардлагатай албан тушаалтанд хэрэгцээт үед нь гаргаж өгнө;

3.6. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч нь салбарын байгууллагын удирдах ажилтан болсноор мал эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн үүрэг хариуцлага нь өөрчлөгдөхгүй;

3.7. Мал эмнэлгийн удирдах ажилтан нь ёс зүйн дараах нэмэлт үүргийг хүлээнэ;

3.7.1. Хариуцсан байгууллага, нэгжийн түвшинд мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ;

3.7.2. Мал эмнэлгийн ажил үйлчилгээ явуулах захиалгат болон төлөвлөгөөт ажлын хөрөнгө санхүүг шударгаар хуваарилах, байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлнэ;

3.7.3. Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ёс зүйн хяналтын хороо болон салбар хороо байгуулан ажиллуулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ;

3.7.4. Энэ дүрмийн 7.1-д заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан эмчийн хүсэлтийг хүлээн авч, шалган, нэн даруй шийдвэрлэнэ;

3.7.5. Мал эмнэлгийн салбарын байгууллагын дарга, үйлчилгээний нэгжийн эзэд, захирал нар нь мэргэжлийн бус хүн байсан ч мал эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг нэгэн адил дагаж мөрдөнө;

3.8. Мэдлэг, ур чадвараа нийгмийн эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх, хэн нэгэнд тохиолдсон эрүүл мэндийн асуудлыг хүнлэг, ёс зүйн үүднээс шийдвэрлэх;

3.9. Мал эмнэлгийн байгууллага, бусад мэргэжилтний нэр төр, мэргэжлийн ур чадвар болон ажлын нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу санаатайгаар хөндлөнгийн хүмүүст болон тэдний дэргэд дэлгэх, шүүмжлэн ярихгүй, бусдыг ийм байдал гаргуулахгүй байх;

3.10. Мэргэжил, мэргэшсэн давуу байдлаа ашиглан мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, саад тотгор учруулах, санаатайгаар мал эмнэлгийн үйлчилгээний чанар, стандартыг алдагдуулахгүй байх;

3.11. Мал эмнэлгийн мэргэжилтэн нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний талаарх албан бичиг баримт, тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх, эсвэл хуурамч бичиг баримтад гарын үсэг зурах, үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой бичиг баримтыг нөхөж бичих, дууриалган засварлах, устгах зэрэг үйлдэл гаргахгүй, бусад хүмүүсийг ийм үйлдэл гаргахаас сэргийлэх;

3.12. Үйлчлүүлэгчидтэй урьдчилан гэрээ байгуулах, захиалга авах, мэдээлэл өгөх зэргээр албан ёсны зөвшөөрөл авалгүйгээр үйлчилгээ үзүүлэхгүй байх;

3.13. Бусдын гэрээт үйлчлүүлэгчид зөвшөөрөлгүй үйлчлэх, шаардлагагүй үйлчилгээг зааварчлахгүй байх;

3.14. Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр түүнийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танигдахуйц байдлаар харуулах буюу бусад хэлбэрээр сурталчилгаанд оруулахгүй байх;

3.15. Үйлчлүүлэгчийг илт төөрөгдүүлэх, худал ташаа мэдээлэл бүхий сурталчилгаа явуулахгүй байх;

3.16. Малын эмч нь Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай, стандартын шаардлага хангасан эм, бодис, биологийн идэвхт бодисоор үйлчлүүлэгчидэд үйлчилхийн зэрэгцээ хуурамч эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх, дэмжиж сурталчлах, зарж борлуулах, түгээх, үйлчилгээг үйлчлүүлэгчид санал болгох, сурталчлах үйлдэлтэй тууштай тэмцэх;

3.17. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч нь үйлчлүүлэгчийг мал эмнэлгийн үйлчилгээ авах, мал эмнэлгийн нэгж, эмчээ сонгох эрхээ эдэлж, сонголт хийхэд нь хувийн ашиг сонирхлын үүднээс хандаж нөлөө үзүүлэхгүй байх;

3.18. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь үйлчлүүлэгчтэй харгис хэрцгий харилцах, нэр төрийг нь доромжлох, басамжлах аливаа хэлбэрийг гаргахгүй, өөрөө оролцохгүй байх;

3.19. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь мал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснийхээ төлөө нормативт үйлчилгээний төлбөрөөс гадна үйлчлүүлэгчээс авлига, хээл хахуул, шан харамж, хандив, бэлэг, албан бус төлбөр авахгүй байх;

3.20. Үйлчлүүлэгч болон хамтран ажиллагсдыг бэлгийн дарамтанд оруулахгүй байх;

3.21. Удирдах ажилтан болон мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч нь давуу байдлаа ашиглан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үйлчлүүлэгч, хамт олон, нийгэмд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, бусдыг татан оролцуулахгүй байх;

Дөрөв. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан үйлчлүүлэгчтэй харилцах, хамтран ажиллах горим

4.1. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь үйлчлүүлэгчидтэй хүнлэг энэрэнгүй хандаж, тэдний хууль ёсны эрх, нэр төрийг хүндэтгэж харилцана;

4.2. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь зөвхөн мал, амьтан, үйлчлүүлэгчийн өмнө хүлээх хариуцлагаар хязгаарлагдахгүйгээр хүрээлэн буй орчинд хор хохирол учруулахгүй, мал, амьтантай зүй зохистой харьцах, хүн амын хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндэд тустай, тэдний сайн сайхны төлөө нийгмийн хүлээлтэд нийцэж ажиллах үүрэгтэй;

4.3. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч нар нь оршин буй нутаг дэвсгэртээ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стратеги, стандарт, төсөл, хөтөлбөр, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй, мал эмнэлгийг удирдлагаар хангах, нийт ард иргэдэд сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй;

4.4. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь мал, амьтантай харьцахдаа зан үйлд нь тохируулан харьцах, бэхлэх, уях зэргээр хөдөлмөр хөнгөвчлөх, мал, амьтны зовлон зүдгүүрийг багасгах, хөнгөлөх, аливаа нэмэлт, зовиур шаналгаа үүсгэхгүй, оновчтой тусламж үйлчилгээ үзүүлэхийг эрмэлзэж, үйлчлүүлэгч, мал эмнэлгийн үйл ажиллагааныхаа тэнцвэрийг тогтмол хангаж ажиллана;

4.5. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь гэрээт үйлчлүүлэгчдийн дунд тухайн орон нутагтаа байнга оршин суугч байж, тогтмол дуудлага, үйлчилгээгээр хангаж ажиллахын зэрэгцээ дуудлага үйлчилгээнд очоогүйгээс иргэнд гарсан хохиролыг шийдвэрлэхэд ёс зүйн хариуцлагыг хүлээнэ;

4.6. Мал эмнэлгийн мэргэжилтэн нь байгууллагын удирдлагатайгаа жил бүр үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, хагас бүтэн жилээр үр дүнг тооцож, хариуцсан ажил үүргийн чиглэлээр салбарын ажилчид, малчид, үйлчлүүлэгчид тогтмол мэргэжлийн үүрэг чиглэл, үйлчилгээ, заавар зөвлөмж өгч ажиллана;

4.7. Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн малын эмч нар нь аливаа ажил үүргийг гүйцэтгэхдээ мэргэжлийн дээд шатны болон оршин суугаа орон нутгийн төр захиргааны байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хувийн малын эмч нар төрийн байгууллага болон үйлчлүүлэгч, малчидтай гурвалсан гэрээ байгуулан үйл ажиллагаагаа эрхэлнэ. Мал эмнэлгийн техникийн ажилтан нар малын эмч нартай гэрээ байгуулан тэдний удирдлаган дор, өгсөн үүрэг даалгаврыг мэргэжлийн түвшинд биелүүлж ажиллана;

4.8. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь мал эмнэлгийн үйлчилгээний зорилго, чиглэл, мөн чанар, ач холбогдол үр дүнгийн талаар үнэн зөв

мэдээллийг үйлчлүүлэгчид тогтмол, энгийн, ойлгомжтой үгээр тайлбарлан таниулж, хамтран ажиллана;

4.9. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь үйлчилгээ үзүүлэхдээ үйлчилгээний ил тод, итгэл даасан үйлчилгээг мэргэжил, ёс зүйн өндөр түвшинд үзүүлэхэд чиглэн, чөлөөт зах зээлийн тогтолцооны орчин үеийн арга барилд түшиглэсэн, тэгш эрхийг ханган ажиллах зарчмыг баримтална;

4.10. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчидтэй албан ёсны гэрээ, харилцан тохиролцоо байгуулах, хийх ажлынхаа талаар урьдчилан дэлгэрэнгүй тайлбар, зөвлөмж, зөвлөгөө өгч үйлчлэн, хийсэн ажлынхаа акт үйлдэж, мал эмнэлгийн үйлчилгээний дэвтэр дээр нь тэмдэглэл хийж, үйлчлүүлэгчийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна;

4.11. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхдээ тухай бүр цаг хугацааг зарлан мэдээлэх, малын эзний зөвшөөрөлгүй, малчин болон холбогдох хүнийг байлцуулалгүйгээр үйлчилгээ үзүүлэхийг хориглоно;

4.12. Малын гоц халдварт өвчин оношлогдсон, цаг үеийн шуурхай зарим арга хэмжээг хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэр гарч, бүх нийтийн дайчилгаагаар ажил гүйцэтгэж, үйлчилгээний цаг хугацаа алдаж, ноцтой үр дагаварт хүргэх үед хамгийн ойрын гэрчийг байлцуулан гүйцэтгэж болно;

4.13. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар, дүрэм, журам болон ялангуяа малын гоц халдварт, халдварт, паразитгах өвчинтэй тэмцэх заавар, стратеги, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн үйл ажиллагааны гол зорилго, чиглэл, мөрдлөгө болгон ажиллана;

4.14. Мал эмнэлгийн үйлчилгээг малчид, үйлчлүүлэгчдэд үзүүлэхдээ улс, аймаг орон нутгийн шийдвэрээр тогтоосон үйлчилгээний хөлсний норм, нормативт үнэлгээг баримтлах ба бусад үйлчилгээний үнэлгээг үйлчлүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэнэ;

4.15. Үхлийн төгсгөлийн шатанд орсон буюу эдгэрэшгүй, өвчтэй мал амьтныг аль болох эмчилгээний үргүй зардал гаргахаас сэргийлж, өвдөлт, зовиур шаналгааг багасган хөнгөвчлөх, амар тайван байдлыг хангах зорилгоор эмчилгээ, үйлчилгээг эзэнд зөв ойлгуулсаны үндсэн дээр уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу тавиланг богино хугацаанд шийдвэрлэхийг эрмэлзэнэ;

4.16. Мал, амьтанд мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэхдээ мэдлэг чадвар, шударга зан, ёс суртахуун, энэрэнгүй үзлийг эрхэмлэн ажиллаж, мал, амьтантай зүй бус харьцаж буй үйлдэлдэй эрс шийдвэртэй тэмцэх, зүй зохистой харьцааг төлөвшүүлэхэд мэргэжилтний ёс зүйг өндөрт өргөж ажиллана;

Тав. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан хоорондын харилцааны горим.

5.1. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан хоорондын харилцаа нь нэг нэгнийгээ харилцан хүндэтгэсэн, ажлыг дэмжсэн, зөвөлгөө, зөвлөмжөөр тогтмол хагаж, хамтын үйл ажиллагааны зарчимд үндэслэнэ;

5.2. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөжийг сайжруулах зорилгоор мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар нь мэргэжил нэгт нөхөдтэйгээ үнэнч, шударга, зах зээлийн зарчмаар чөлөөтэй өрсөлдөнө;

5.3.Төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшилд ажиллаж байгаа мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар нь шат дараалсан удирдах, удирдуулах ёс, дэг жаяг, үнэнч, шударга зарчмыг хүндэтгэн ажиллана;

5.4.Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргах, үйлчлүүлэгчдэд хайхрамжгүй хандах, хуурах, залилан мэхлэхтэй эвлэрэшгүй тэмцэж байхын зэрэгцээ эдгээр үйлдлээс өөрийгөө болон мэргэжил нэгтнээ сэргийлэн хамгаалж ажиллана;

5.5.Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх явцдаа өөрийн санаачлага, үйлчлүүлэгчийн хүсэлтээр мал эмнэлгийн мэргэжлийн байгууллага, эрдэмтэд, зөвлөх эмч болон бусад мэргэшсэн хүмүүсээс зөвлөгөө авч, тусламжийг үзүүлж болно;

5.6.Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар аливаа асуудлыг шийдвэрлэхдээ салбарын хууль тогтоомж, бусад эрх зүйн акт, стандарт, журам, дүрэм, зааврыг баримтлан ажиллах бөгөөд холбогдох саналаа боловсруулж дээд шатны албан тушаалтан, байгууллагадаа тавьж шийдвэрлүүлнэ;

5.7.Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн малын өвчин эмгэгийн байдал, түүний тархалт, эрсдэл, тэмцэж буй арга хэмжээ, ажил үйлчилгээнийхээ талаарх өөрт байгаа мэдээллээ өөр хоорондоо чөлөөтэй солилцож, харилцан ойлголцож, асуудлыг хамтран шийдвэрлэх, санал боловсруулах;

5.8. Мэдээллийг дараах хүмүүст албан ёсоор хүргэнэ;

5.8.1. өөрийг нь шууд удирдан ажилладаг мэргэжлийн дээд шатны албан тушаалтан, байгууллага;

5.8.2. байгууллагын зөвлөх мэргэжилтэн, хамтран ажилладаг мэргэжилтэн, малын эмч;

5.8.3. тухайн орон нутгийн засаг захиаргаа, бусад холбогдох байгууллага, газар, хэлтэс, албан тушаалтан;

5.8.4. хуулиар олгогдсон эрх бүхий бусад үйлчлүүлэгч малчид, иргэд;

5.9. Мал эмнэлгийн нэгжийн эмч, техникийн ажилтан нь гэрээт малчид, мал бүхий иргэддээ үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд, тухайн орон нутагт үйлчилгээ үзүүлэхийг хүссэн малын эмч нь урьд нь ажиллаж байсан гэрээт малын эмчтэй зөвшилцөж, орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүсэлт гаргаж, бүртгүүлж зөвшөөрөл авсаны үндсэн дээр үйлчилгээг үзүүлж болно;

5.10.Малын эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан нар нь мал эмнэлгийн стандарт, дүрэм, журам, зааварт нийцээгүй мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, эмчилгээ, оношлогоог бусдын заавраар хийж гүйцэтгэхээс татгалзах эрхтэй бөгөөд хэрэв тийм үйлдэл хийхийг шаардсан, зааварласан тохиолдолд шууд харъяалах дээд албан тушаалтанд мэдээнэ;

5.11.Малын эмч нь өөрийн залуу халаагаа байнга бэлтгэж, сургаж дадлагажуулж, дэмжиж ажиллана;

Зургаа. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар нийгэмтэй харилцах горим.

6.1.Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, бусад холбогдох

хууль тогтоомж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын шийдвэрийг хэрэгжүүлж, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж, мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, худалдааны чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдтэй үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана;

6.2. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь нийгэм, олон нийт, үйлчлүүлэгчийн эрх ашгийг өөрийн хувийн ашиг сонирголоос дээгүүрт тавина;

6.3. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь олон улсын болон бусад хандив, тусламж, халамж, буяны байгууллага, сайн санаат иргэдээс мал эмнэлгийн арга хэмжээнд зориулан өгсөн тусламж дэмжлэгийг зориулалтын дагуу үр дүнтэй ашиглана;

6.4. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч нар нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, интернет, утсан харилцааны хэлбэрээр нийтэд зөвлөгөө, мэдээлэл өгч, мэргэжлийн сурталчилгаа хийхдээ зөвхөн үнэн зөв, энгийн, тодорхой, олон нийтэд ойлгогдохоор хуульд заасан хүрээнд зохион байгуулна;

6.5. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь мал эмнэлгийн арга хэмжээ, урьдчилан сэргийлэлт, эмийн хэрэглээ, эмчилгээ, үйлчилгээний аргатай холбоотой хууль бус, ташаа, худал хуурмаг, ойлгомжгүй, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актад нийцээгүй мэдээлэл, сурталчилгааны талаар холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй;

Долоо. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах

7.1. Малчид, мал бүхий иргэд, үйлчлүүлэгчид мал эмнэлгийн арга хэмжээнд хамруулахаар тогтоосон хугацаанд, зарласан газар мал сүргээ бэлэн байлгаагүй, мал барих туслах хүн хүчээ бэлтгээгүйгээс ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх байдал үүсгэсэн, бие махбодид нь халдах, заналхийлэх, айлган сүрдүүлсэн, ёс бусаар харьцсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нар татгалзах болсон үндэслэлээ үйлчлүүлэгч, өөрийн байгууллагын удирдлагад бичгээр мэдэгдэнэ.

7.2. Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан нь малчид, мал бүхий иргэд, үйлчлүүлэгчийн хүсэлт, шаардлага, дуудлага нь хууль ёсны биш гэж үзвэл татгалзаж болно.

Найм. Ёс зүйн хэм хэмжээг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага

8.1. Мал эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэв хэмжээг зөрчсөн нь шалгалтаар тогтоогдсон, ёс зүйн хорооны болон салбар хорооны шийдвэрийг биелүүлээгүй Мал эмнэлгийн мэргэжилтэн, малын эмч, техникийн ажилтан холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.